

БАТЛАВ
БӨМБӨГӨР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА 
М.МОНХ-ЭРДЭНЭ

БӨМБӨГӨР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 06 сарын 24

Бөмбөгөр

Ард иргэд нь ажлын байртай, орлоготой орон нутгийнхаа онцлогт тохирсон хөгжлийн хөтөлбөртэй, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд жигд хөгжсөн Баянхонгор аймгийнхаа тэрүүний сум болно.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Орлоготой иргэн

- 1.1.1 Үйлдвэрлэл үйлчилгээг эрхэлж буй иргэдийн ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж гадаад дотоодод суралцах боломжуудыг судалж өргөнөөр хамруулна.
- 1.1.2 Өрхийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.3 Малчдын орлогыг нэмэгдүүлж мах, ноос, ноолуурын урамшуулалд малчидaa бүрэн хамруулна. Таваарлаг аж ахуйг хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Гадаад дотоодын төсөл хөтөлбөрт иргэдээ хамруулж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.2 Эрүүл иргэн

- 1.2.1 "Эрүүл шүд - эрүүл хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлж сумынхаа иргэдийг бүрэн хамруулна.
- 1.2.2 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.3 "Элэг бүтэн Баянхонгор" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- 1.2.4 Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэх дасгал, эрүүл амьдралын хэв маягийг
- 1.2.5 дэмжих замаар халдварт бус өвчлөлийг бууруулан, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.
- 1.2.6 Сумын бүх иргэдийг жилд 2-оос доошгүй удаа нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулна.

1.3 Чанартай боловсрол

- 1.3.1 Бага сургуулийн шинэ барилгыг барьж ашиглалтад оруулан Сургуулийн дотуур байрыг шинэчилнэ.
- 1.3.2 Байгаль эхийн ховор нандин үзвэр түүхийн дурсгалт газруудыг иргэдийн санаачилга төрийн дэмжлэг оролцоотойгоор хамгаалж. Орон нутаг судлах музейг засварлаж өргөтгөнө.
- 1.3.3 Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэн, тогтвортой суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

0000000001



1.3.4 Хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлого боловсруулна.

1.4 Тогтвортой-Амар амгалан гэр бүл

- 1.4.1 Гэр бүлийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын амралт чөлөөт цагийг зав боловсон өнгөрүүлэх “Залуус” хөгжлийн төвтэй болно.
- 1.4.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамж үйлчилгээг төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.3 Хөдөлмөр эрхлэх жуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.

1.5 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр

- 1.5.1 Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах боломжийг бүрдүүлж цэцэрлэгийн өргөтгөлийг ашиглалтад оруулах.
- 1.5.2 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

1.6 Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.6.1 Залуу гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.7 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дэмжих

- 1.7.1 Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, тэгш хамран сургах, нөхөн сэргээх өдрийн үйлчилгээг дэмжин ажиллана.

1.8 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

- 1.8.1 Ахмад настны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, цэцэрлэгт хүрээлэнг байгуулах, сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.9 Үндэсний бахархал, өв соёл, спорт

- 1.9.1 Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 Төв зам дагуу үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, эрчим хүчний асуудлыг шийдвэрлэж, аялал жуулчлалыг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Сумын төвийг нэгдсэн халаалтын системтэй болгоно.
- 3.2 Сумын төвийн шинэчлэл төсөлд хамрагдаж “Шинэ хөдөө” төслийг сумандаа хэрэгжүүлнэ.
- 3.3 Төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй иргэдийн оролцоотой хүргэж, “Цахим Монгол хөтөлбөр” хэрэгжүүлэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 3.4 Ард иргэдийг соён гэгээрүүлж, Үндсэн хуулийн шинэчлэлтийг сурталчилж, иргэдэд ээлтэй төр, төрийн албыг бүрдүүлж ажиллана.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

000000002

- 4.1 Голын ай савыг хамгаалж иргэдээ баталгаатай ундны усаар хангана.
- 4.2 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн эдгэрсэн газруудад тооллого явуулж үнэлгээ тогтоолгож нөхөн сэргээх ажлыг хийнэ.
- 4.3 Бичил уурхайтай холбоотой хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.
- 4.4 Сумын төвийн хог хаягдлыг ангилан ялгаж шаардлагатай хог хаягдлыг ашиглан дарж устгана.
- 4.5 Сумын байгалийн үзэсгэлэнт газар болон түүхэн дурсгалт газруудад аялал жуулчлалын маршрут гарган эко аяллыг дэмжинэ.

ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Сумын хэмжээнд инженерийн хийцтэй худаг гаргах, алслагдсан бус нутгийг усжуулан бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ.
- 5.2 Малчин өрхийн мал сүргийг байгалийн болон болзошгүй эрсдэлээс хамгаалах учрах эрсдэлийг нөхөж дэмжлэг үзүүлнэ.
- 5.3 Шилмэл хээлтүүлэгчийн сан хөтөлбөрийг үргэлжлүүлэн, Өлзийт голын Улаан ямааны омгийг үүлдэр болгоно.
- 5.4 Малын хулгайтай тэмцэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 5.5 Монгол мал 2 хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.6 Атрын 4-р аяны хүрээнд органик хүнс үйлдвэрлэж, газар тариаланг хөгжүүлнэ.

ооо

000000003